

Төв аймгийн Аудитын газраас “Эрүүл чийрэг монгол хүн” үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтэнд Гүйцэтгэлийн аудит хийсэн тухай товч тайлбар.

2015-02-25.

Зуунмод хот

Монгол Улсын их хурлын 2012 оны 37 дугаар тогтоол, Засгийн газрын 2012 оны 120 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Эрүүл чийрэг монгол хүн” /2012-2016/ үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр нийт 22 зорилт, 48 хэрэгжүүлэх арга хэмжээнээс аймгийн Эрүүл мэндийн газар аймгийн хэмжээнд 13 зорилтын 21 арга хэмжээг хэрэгжүүлэх төлөвлөгөө гарган хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Бусад 9 зорилтын 27 арга хэмжээ нь яамдуудын хэрэгжүүлэх асуудал юм байна.

Тус хөтөлбөрийн хэрэгжилтийг аймгийн Нийгмийн хөгжлийн хэлтсийн эрүүл мэндийн асуудал хариуцсан мэрэгжилтэн, Эрүүл мэндийн газар, Нэгдсэн эмнэлгийн болон бусад холбогдох ажилтнуудыг хамруулан байгууллага дээр нь очиж холбогдох албан тушаалтнуудтай уулзаж ярилцан хөтөлбөрийн хэрэгжилттэй холбогдох баримт бичигтэй танилцан, тулган нотлох замаар гүйцэтгэлийн аудитыг хийлээ.

Энэхүү төлөвлөгөөний хэрэгжилтийн байдлыг авч үзвэл аймагт хэрэгжүүлбэл зохих төлөвлөгөөний 5 арга хэмжээг 90 хувиар, 7 арга хэмжээг 70 хувиар, 5 арга хэмжээг 50 хувиар, 4 арга хэмжээг 30 хувиар биелүүлж нийтдээ 62,3 хувийн хэрэгжилттэй гэж тайлагнасан байдлыг аудитын явцад газар дээр нь очиж шалгаж үзээд 2 арга хэмжээг 90 хувийн, 7 арга хэмжээг 70 хувийн, 5 арга хэмжээг 50 хувийн, 4 арга хэмжээг 30 хувийн, 1 арга хэмжээг 20 хувийн, 2 арга хэмжээг хэрэгжүүлж эхлээгүй байгаа нь нийт дүнгээрээ 50,5 хувийн хэрэгжилттэй байна гэж дүгнэлээ.

Энэ хэрэгжээгүй хоёр арга хэмжээг тодруулбал:

1. Хүрээлэн буй орчноос хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх хүчин зүйлсийг тодорхойлох нөлөөллийн үнэлгээний тогтолцоог бүрдүүлж, эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авна.

2. Эрүүл мэндийн ажилтны мэдээллийн нэгдсэн сан байгуулж, эрүүл мэндийн байгууллага, иргэдэд ил тод болгоно гэсэн төлөвлөгөөт арга хэмжээнүүд хэрэгжиж эхлээгүй байна.

Тус хөтөлбөр 2012-2016 онд хэрэгжих тул хэрэгжих хугацаа болоогүй, эхлэлтийн шатанд яваа, Эрүүл мэндийн яам болон бусад яам, хууль эрх зүйн өөрчлөлтөөс шалтгаалан нилээд арга хэмжээнүүд хэрэгжиж эхлэх болон хэрэгжих шатандаа явж байна. Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үлдсэн хугацаанд хэрхэн ажиллах талаар арга зүйн зөвлөмж өгч ажиллаа.

Аудитор

Д.Пүрэвсүрэн